

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 1/477 тоот албан бичгээр өргөн барьсан саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын байгаль, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах, нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн “Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр” /2013-2016/ -ийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАТТУЛГА

**УЛААНБААТАР ХОТЫН ХОГ ХАЯГДЛЫН
МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР
/2013-2016/**

Нэг. ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын нийслэл Улаанбаатар хот нь 4704 км² газар нутагтай, 1206 мянган хүн амтай, хурдацтай өсч байгаа хот юм. Орон нутгийн иргэд нийгмийн хөгжлийг дагаж мэдээллийн хүртээмж сайтай, хүн ам илүү төвлөрсөн, дэд бүтцийн сүлжээтэй орон зай руу тэмүүлж байгаа нь хотын хүн амын өсөлтийн гол эх сурвалж болж байна.

Ерээд оны нийгмийн тогтолцооны шилжилтээс хойш сулраад байсан хот тохижилт, хог хаягдлын асуудалд төр засаг, албан байгууллага, иргэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлийн ажлуудыг хийж хэвшин үр дүнд хүрч байна. Үүнийг тоймлон дурьдвал:

- Бүх нийтийг хамарсан цэвэрлэгээг хийж тогтмолжуулсан
- Улаанбаатар хотын Ерөнхий боловсролын сургуулийн 7-р ангиас хог хаягдлын менежментийн талаар лекц, сургалт орж эхэлсэн.
- Хууль бус хог хаях явдлыг таслан зогсоох зорилгоор хотын зүгээс өөрийн хөрөнгөөр хог тээврийн автомашин худалдан авч, хог тээврийн үйлчилгээг эрчимжүүлэх ажлуудыг хийж эхэлсэн.
- Зарим байрнуудын гаднах хогийн цэгийг хааж, дуут дохиогоор үйлчлэх тогтолцоог нэвтрүүлсэн
- Гэр хорооллын хог цуглуулалтын хэмжээ 2006 онд 43% байсан бол өдгөө 60% гаруй хувьтай болсон сайн талтай ч зарим байршлуудад сардаа 2 удаа хог ачилт хийгдэж чадахгүй байгаагаас гуу жалганд ил задгай хог үүссэн хэвээр байна.
- Гэр хорооллын айл өрхөөс хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөртэй хамт авдаг болсноор хогны хураамжийн хувь хэмжээ огцом өсч төлбөр хураалт 2011 оны 7 сард 28% байсан бол 2011 оны эцэст 61% болж өссөн. Хэдий тийм боловч ч нийт хураамжийн орлогын 23%-ийг шимтгэгдэж байгааг эргэн харах шаардлагатай байна.
- Тээвэрлэсэн хогийг рейсийн тоогоор биш автопүүгээр хэмжих тогтолцоо хэрэгжиж эхлээд байна.
- Хог ангилан ялгах, боловсруулах жижиг үйлдвэрийг Нарангийн энгэрийн хогийн цэгийг түшиглэн барьж дууссан бөгөөд энэ оноос үйл ажиллагаагаа эхлэх зэрэг ажлууд хийгдэж байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах талаар нилээдгүй ажлууд хийгдэж байгаа ч хотын хүн амын эрчимтэй өсөлттэй холбоотой хэрэглээ нэмэгдэж, төлөвлөлтгүй суурьшлууд бий болж, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд хүндрэл бий болсоор байна. Агаар, хөрсний бохирдол, хөдөлгөөний саатал, ногоон байгууламжийн хомсдол, хог хаягдлын хотын тулгамдсан асуудалууд хэвээр байна.

1.1.Улаанбаатар хотын хог хаягдлын урсгалын өнөөгийн байдал

Хотын хэмжээнд 2008 онд өдөрт дунджаар 1000тн хог хаягдал гарч байсан бол 2012 оны байдлаар 1500 тн болж нэмэгджээ. Хог ангилан ялгах, боловсруулах, ашиглах, тээвэрлэх ажлууд хийгдэж байгаа хэдий ч тогтолцооны түвшинд шийдэх олон асуудлууд байгааг Япон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ийн судлаачдын хийсэн судалгаа харуулсан.

Хүснэгт 1 УЛААНБААТАР ХОТЫН ХОГ ХАЯГДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Зүйл	Тоо хэмжээ (2012)
1	Хог хаягдлын ачилт (%) Орон сууцны хороолол Гэр хороолол	90 63
2	Өөрөө устгах хувь хэмжээ ба хог хаягдлын гарах хэмжээнд эзлэх хууль бус хог хаягдлын хувийн жин (%) <ul style="list-style-type: none"> • Өвөл • Зун 	4.4 2.8
3	Орон сууцны хорооллын хог хаягдлыг ангилан цуглуулах <ul style="list-style-type: none"> • Ангилан цуглуулах хэмжээ (%) • Хамрагдах хүн ам (хүн) 	0 0
4	Хог хаягдлын хэмжээнд эзлэх ангилан цуглуулах хэвь хэмжээ (%) <ul style="list-style-type: none"> • Өвөл • Зун 	0 0
5	Хог хаягдлын хэмжээнд эзлэх дундын боловсруулалтын хувь хэмжээ (%) <ul style="list-style-type: none"> • Өвөл • Зун 	0 0
6	Хог хаягдлын хувь хэмжээнд ангилан ялгах буюу Recycle үйл ажиллагааны хувь хэмжээ (%) <ul style="list-style-type: none"> • Өвөл • Зун 	3.7 (0.0) 8.4 (0.0)
7	Хогийн төвлөрсөн цэг дээр хог хаягдлын дарж булах аргачлал НЭХЦ Бусад 3 хогийн цэг	Эрүүл ахуйд нийцсэн ландфил: 4-р түвшин 2-р түвшин

Мэдээллийн эх үүсвэр: УБЗАА, ХТГазрын мэдээллийн дотоод судалга болон ЖАЙКА “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл-2012”.

1.2.Тулгамдаж буй асуудал

Хог үүсэхээс эхлээд хогийн цэг хүртэлх үйл явцад олон асуудлууд шийдлээ хүлээж байна. Тухайлбал:

Үйл ажиллагаатай холбоотой

- Ил задгай үүсмэл хог хаягдал үүсэх
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах соёл нэвтрээгүй
- Гудамж, зам, талбайн цэвэрлэгээ хангалттай хэмжээнд хийгдэхгүй
- Орон сууцны дундах нийтийн эзэмшлийн зам талбай, гэр хорооллын дундах зам талбайн өдөр тутмын цэвэрлэгээ орхигдсон
- Иргэдийн ахуйн хог хаягдалд хандах ухамсар, соёлын түвшин доогуур
- Барилгын хог хаягдлыг хууль бусаар ихээр асгах
- Ахуйн болон бохир шингэн хог хаягдлыг зориулалтын бус газар асгах

Техник, технологийн шийдэлтэй холбоотой

- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээнд хэрэглэгдэж байгаа багаж хэрэгсэл хоцрогдсон
- Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах техник, технологийн шийдэл, боловсруулах үйлдвэрлэлийн туршлага байхгүй, үйлдвэр барих ажил эхлэлийн шатандаа байна.
- Техник тоног төхөөрөмж, боловсон хүчний хангамж, түүнийг нэмэгдүүлэх асуудлууд.
- Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа, технологи, мониторингийн тогтолцоо (камержуулах)

Оролцогч талуудын түвшинд:

- Хог хаягдлын менежментэд оролцогч талуудын чиг үүргийг оновчтой болгох, хамтын ажиллагаа, уялдааг бэхжүүлэх
- Хог хаягдлын төлбөр тооцоо, цуглуулалттай холбоотой санхүүгийн механизмыг боловсронгуй болгох
- Хяналт, шалгалт, мониторингийн тогтолцоог боловсронгуй болгох

Анхаарч бодлого чиглэлд тусгах асуудлууд:

- Эмнэлэгийн болон аюултай хог хаягдал
- Шингэн хог хаягдлын асуудлууд орно.

2. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хөтөлбөрийн баримтлах зарчмийг дараах байдлаар томъёолов.

- Хууль дээдлэх
- Залгамж чанараа хадгалах
- Шударга, ил тод байх
- Иргэдийн оролцоог дэмжих
- Хариуцлагатай байх
- Эрх тэгш байх
- Бодитой, үр дүнтэй байх
- Асуудал бол боломж

3. ҮНДСЭН ЗОРИЛГО

Энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго нь **“Нийслэлийн иргэдийг эрүүл, аюулгүй, орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах хог хаягдлын менежментийн тогтолцоог бий болгох”** юм.

Уг зорилгод хүрэхийн тулд “Монгол улсын засгийн газрын 2012- 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөвдүгээр бүлэг буюу “Аюулгүй орчинтой монгол хүн”, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013- 2016оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн нэгдүгээр бүлэг буюу “Агаар цэвэр Улаанбаатар” зэрэг төр засгийн бодлого чиглэл, ЖАЙКА олон улсын байгууллагын хийсэн “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын хөгжлийн судалгаа” 2004-2007 он, “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл” 2009–2012 онуудад хийгдсэн судалгааны ажлын үр дүн, тоо баримт, зөвлөмжүүд зэрэг нь энэхүү хөтөлбөрийн үндэс суурь болов.

4. ЗОРИЛТ

Хөтөлбөрийн зорилтыг ойлгомжтой, хэмжигдэхүйц, залгамж чанараа хадгалсан, үр дүнтэй нөхцлийг харгалзан үзэж дараах байдлаар тодорхойлов.

- Хог хаягдалыг анхан шатны эх үүсвэр дээр ангилан ялгаж, гарах хог хаягдлын хэмжээг багасгах ажиллагааг дэмжих
- Нэгэнт үүссэн хог хаягдлыг дахин ашиглах, хэрэглээнд оруулах
- Ангилсан хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх ялгах, дахин боловсруулах ажлуудыг хийж эцсийн шатанд байгаль орчинд сөрөг нөлөөг бага үзүүлэх технологи ашиглан хогийн цэг дээр дарж устгах
- Нээлттэй, шударга зарчим баримтлан төр засаг, хувийн хэвшил, олон нийт тус тусын зохих хариуцлага хүлээх, хамтын ажиллагааг бэхжүүлэх

Дээрх зорилтуудын томъёололд хэмжигдэхүйц байх гэж заасны дагуу шалгуур үзүүлэлтүүд, хүрэх хувь хэмжээг төлөвлөв.

Хүснэгт 2 ЗОРИЛТУУД, ХҮРЭХ ТҮВШИН

№	Зүйл	Хувь хэмжээ	Хувь хэмжээ	Өөрчлөлт
---	------	-------------	-------------	----------

		(2012) <i>Гарааны түвшин</i>	(2016) <i>Барианы түвшин</i>	(2013-2016)
1	Хог хаягдлын хэмжээ (%) Орон сууцны хороолол Гэр хороолол	90 63	100 95	10% ↑ 32% ↑
2	Өөрөө устгах хувь хэмжээ ба хог хаягдлын гарах хэмжээнд эзлэх хууль бус хог хаягдлын хувийн жин (%) • Өвөл • Зун	4.4 2.8	1.9 1.4	2.5 ↓ 1.4 ↓
3	Орон сууцны хорооллын хог хаягдлыг ангилан цуглуулах • Ангилан цуглуулах хэмжээ (%) • Хамрагдах хүн ам (хүн)	0 0	18.45 90.000	18.45 ↑ 90.000 ↑
4	Хог хаягдлын хэмжээнд эзлэх ангилан цуглуулах хувь хэмжээ (%) • Өвөл • Зун	0 0	2.7 3.8	2.7 ↑ 3.8 ↑
5	Хог хаягдлын хэмжээнд эзлэх дундын боловсруулалтын хувь хэмжээ (%) • Өвөл • Зун	0 0	1.3 1.9	1.3 ↑ 1.9 ↑
6	Хог хаягдлын хувь хэмжээнд ангилан ялгах буюу Recycle үйл ажиллагааны хувь хэмжээ (%) • Өвөл • Зун	3.7 (0.0) 8.4 (0.0)	4.9 8.3	4.9 ↑ 8.3 ↑
7	Хогийн төвлөрсөн цэг дээр хог хаягдлын дарж булах аргачлал НЭХЦ Бусад 3 хогийн цэг	Эрүүл ахуйд нийцсэн ландфил: 4-р түвшин 2-р түвшин	Эрүүл ахуйд нийцсэн ландфил: 4-р түвшин 2-р түвшин	- -

Тайлбар: Дээрх хүснэгтийн үзүүлэлтүүд нь ЖАЙКА болон УБ ЗАА-ны хүмүүсийн хамтын ажиллагаа, судалгаагаар тодорхойлогдсон болно.

5. СТРАТЕГИ

Хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд дараах стратегиудыг баримтлан ажиллана.

5.1 Институцын түвшинд:

Хүснэгт 3 ИНТИТУЦЫН ТҮВШНИЙ СТРАТЕГИ

№	Стратеги	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Эх үүсвэр дээрхи хог хаягдлын менежментийн тогтолцоог сайжруулах	Хот, дүүрэг хороодын гүйцэтгэх, үүрэг, удирдлагын тогтолцоог шинэчлэн сайжруулна. Ялангуяа хог хаягдлыг анхан шатанд үүсгэгч иргэн, байгууллага аж ахуйн нэгжтэй шууд харьцах дүүрэг хороо, хэсгийн ахлагч, СӨХ-ийн гүйцэтгэх үүргийг тодорхой болгон бэхжүүлэх.
2	ХХМ-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг бэхжүүлэх	ХХМ-ийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагуудын удирдлага, хяналтын тогтолцоог улам бэхжүүлэх <ul style="list-style-type: none"> ▪ Зөвхөн ахуйн хатуу хог хаягдалд анхаарлаа хандуулах биш аюултай болон эмнэлгийн хог хаягдал, шингэн хог хаягдлын асуудалд одооноос ач холбогдол өгөх. Энэ дагуу холбогдох байгууллагууд (УБЗАА, НМХГ, НОБГ, ДЗДТГ гм) дээрх хог хаягдлыг үүсгэн хаягч этгээдийн үйл ажиллагааг хянах, чиглэл өгөх, удирдах тогтолцоог бэхжүүлнэ. ▪ ХХМ-ийг сайжруулахад иргэдийн мэдлэг, ухамсрыг

		дээшлүүлэхэд голлож ажилладаг дүүрэг, хороо, хэсгийн ахлагчдын иргэдтэй хамтран ажиллах чадварыг бэхжүүлэх. Энэ чиглэлийн хичээлийг ЕБС – ийн сургалтын хөтөлбөрт суулган 7-р ангийн хөтөлбөрт оруулсан байгааг бага наснаас буюу сургуулийн өмнөх насны сургалтын хөтөлбөрт оруулж өгөх.
3	Хувийн хэвшлийн оролцоог дэмжих	<p>Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн компаниудын оролцоог үргэлжлүүлэн дэмжих зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хог цуглуулах үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн жишиг баримт бичиг, хэрэгжүүлэх механизмийг ашиглан дүүргүүдэд сонгон шалгаруулдаг болох ▪ Дүүрэг бүр хог хаягдлын менежментийн асуудлаа бие даан шийддэг болхийн тулд бүтэц, орон тоог бий болгох ▪ Аюултай болон эмнэлгийн хог хаягдал, шингэн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менементэд оролцогч хувийн хэвшлийн байгууллагуудыг төрөөс бодлогоор дэмжих
4	Хүний нөөц бэхжүүлэх, иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Дүүрэг, хорооны шатанд хог хаяхгүй байх ухамсрыг төлөвшүүлэх талаар иргэд олон нийт, хувийн хэвшлийнхэнд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлуудыг (хэвлэл мэдээллийн салбарыг татан оролцуулах) зохион явуулах ▪ Японы техник хамтын ажиллагааны төслийн хүрээнд боловсруулсан “Хог тээврийн автомашины ашиглалт, үйлчилгээний гарын авлага”, арга туршлагыг дүүргүүдийн хог хаягдал хариуцсан ажилтнууд болон хувийн компаниудын холбогдох ажилтнуудад сургалт, семинар зохион явуулах ▪ Дүүрэг, хороодын холбогдох мэргэжилтнүүд хог хаягдлын чиглэлээр сургалт зохион байгуулах
5	Хяналт, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ ХХМ-ийн мэдээллийн бааз суурийг бэхжүүлэх, түүнд дүн шинжилгээ хийн, үнэлэлт, дүгнэлт өгөх шуурхайн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий тогтолцоог бүрдүүлэх. (УБЗАА-ны Мониторингийн хэлтэс, ТХХУХэлтэс дүүрэг хороодыг мэдээлэл, удирдлагаар хангаж ажиллах, Шуурхай удирдлагаар хангах 24/7 диспечерийн алба, гм) ▪ Төвлөрсөн хогийн цэгүүдийг камержуулах ▪ НЭХЦ-ийн автопүүнд тулгууралсан бүртгэлийн системийг МДХЦ, ЦДХЦ-т суурилуулж, мэдээллийн нэгдсэн бааз үүсгэж, холбогдох байгууллагуудад онлайнаар хүргэх боломжийг бүрдүүлэх ▪ Хог тээвэрлэх үнэлгээг дүүрэг бүрээр нарийвчлан гаргаж, зохистой үнэлдэг үйлчилгээний зарчмийг хэрэгжүүлэх ▪ Зөв, зохистой үнэлдэг болгохын тулд ТХХУХ-ийн зүгээс зааварчилгаа, гарын авлагаар хангаж, сургалтуудыг зохион байгуулах ▪ Хог цуглуулж, тээвэрлэх үйл ажиллагаанд мэдээллийн технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх

5.2 Техник, технологи, үйл ажиллагааны түвшинд:

Хүснэгт 4: Техник, технологи, тутмын үйл ажиллагааны стратеги

№	Стратеги	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Ангилан тээвэрлэлтийн тогтолцоог өргөжүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Ангилан тээвэрлэлтийн тогтолцоог өргөжүүлэх 2016 он гэхэд орон сууцны хорооллын нийт 90 000 оршин суугчдыг уг үйлчилгээнд хамруулна. ▪ Ангилан ялгах хог хаягдлын төрлийг хог ялгах цех, хог боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээг үндэслэн шинэчлэх
2	Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний тогтолцоог бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Зам талбайн цэвэрлэгээний үйлчлэгчдийн тоог нэмэгдүүлж 800-д хүргэх ▪ Хөдөлмөрийг багаж зэвсгийг сайжруулах арга хэмжээ авах, ▪ Дотоодын зохион бүтээгчдийн шинэ санаа, санаачлагыг дэмжих, хамтран ажиллах
3	Хог хаягдлыг багасгах	<ul style="list-style-type: none"> ▪ Анхан шатны эх үүсвэр дээр нь хог хаягдлын хэмжээг багасгах үйл ажиллагааг дэмжих, Хог хаягдлыг зориулалтын уут, саванд хийлгэж хэвшүүлэх (өөр уутанд хогоо хийсэн айлын хогыг авахгүй байх, торгох гм механизмийг хэрэглэх), ▪ Хог хаягдлыг дахин боловсруулах ▪ Хоёрдогч түүхий эд цуглуулахад чиглэсэн эх үүсвэр дээр нь ангилан ялгалтыг нэмэгдүүлэх (recycle) ба энэ нь төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжсэн үйл ажиллагаа, арга хэмжээг зохион явуулах
	Төвлөрсөн хогийн цэг менежментийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> ▪ Төвлөрсөн хогийн цэгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх (ЖАЙКА төслийн багийхан 2020 хүртэл төвлөрсөн хогийн цэгүүдийн тоог нэмэх шаардлаггүй, харин хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх замаар шийдэх боломжтой гэж тооцоо хийсэн). ▪ Хог тээвэрлэлтэд замын бөглөрлөөс үүдэх нөлөөллийг багасгах арга хэмжээ авах, маршрутын зохицуулалт хийх ▪ 2013 онд Цагаан даваанд шинээр хогийн цэг ашиглалтад орно. Тэнд ландфил технологийг нэвтрүүлэх
	Рисайкл үйл ажиллагааг дэмжих	<ul style="list-style-type: none"> ▪ Нийтийн эзэмшлийн рисайкл цех (НЭРЦ) –ийн ялгах цех, RDF –ийн үйлдвэрийн хог ялгах, түлш үйлдвэрлэх, хүчин чадлыг нэмэгдүүлж 2016 он гэхэд 800 тн/жил-д хүргэнэ. Үүний дүнд рисайклд орох хогны нийт хогонд эзлэх хувийн жинг үүсэх хогны нийт хэмжээ нэмэгдэхээс үл хамааран 2016 он гэхэд өвөлдөө 42.2% -д хүргэнэ ▪ Төвлөрсөн хогын цэгүүд, хог боловсруулах үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах арга хэмжээ авна. Тухайлбал менежментийн хувьчлал хийх, өргөтгөх, шинэ технологи нэвтрүүлэх гэх мэт үр ашгийг дээшлүүлэх арга замуудыг эрэлхийлнэ.
	Эмнэлгийн болон үйлдвэрлэлийн аюултай хог хаягдлыг зүй зохистой боловсруулах	<ul style="list-style-type: none"> ▪ Энэ чиглэлийн хууль эрх зүйн актыг боловсруулна. ▪ Одоогийн түвшинг судлан тогтоож, зохистой боловсруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлнэ. ▪ Шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах байгууламжийг барих, барьж боловсруулах шат эхлэх хүртэл эх үүсвэр дээр нь боловсруулах, аюулгүй хадгалах боломж бололцоог бий болгоно.

	<ul style="list-style-type: none"> Үйлдвэрийн аюултай болон эмнэлэгийн хог хаягдлыг хууль журмын дагуу боловсруулж устгана. Тусгай зориулалтаар баригдсан байгууламж, хогийн цэг дээр боловсруулж, дарж булах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.
--	--

6. ХӨТӨЛБӨРИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ҮЕ ШАТ

6.1 Үргэлжлэх хугацаа

Хүснэгт 5: Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа

2013 он				2014 он				2015 он				2016 он			
I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV
Боловсруулах, батлуулах															

6.2 Үе шат

Төлөвлөсөн зорилгод хүрэхийн тодорхойлсон стратеги барьж ажиллах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг тус тусын зорилготой 2 үндсэн үе шаттайгаар хийнэ. Хөтөлбөрийг 2013-2016 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- **Нэгдүгээр үе шат:** 2013-2014 он
- **Хоёрдугаар үе шат:** 2015- 2016 он

7. УЛААНБААТАР ХОТЫН ХОГ ХАЯГДЛЫН УРСГАЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Улаанбаатар хотын хог хаягдлийн өнөөгийн байдалд тулгуурлан хөтөлбөр хэрэгжсэнээр 2016 онд хог хаягдлын урсгалын төлөвлөлтийг хүснэгтээр харуулав.

7.1 Улаанбаатар хотын хог хаягдлын хэмжээний төлөвлөлт Улаанбаатар хотын хог үүсэх хэмжээ

Хүснэгт 6: Хог хаягдлын хэмжээний төлөвлөлт 2016 оны байдлаар

Ангилал	Нэгж	Өвлийн улирал					Зуны улирал					
		2012 Гараа ны түвшин	2013*	2014*	2015*	2016* Бари аны түвшин	2012 Гараа ны түвшин	2013*	2014*	2015*	2016* Бари аны түвшин	
Өрхийн хог	Орон сууц	Тн/өдөр	146.7	158.9	172.2	185.4	198.6	127.3	137.4	147.6	157.7	167.9
	Гэр (ерөнхий)	Тн/өдөр	122.4	134.0	145.6	157.2	168.8	161.9	175.2	188.5	201.8	215.1
	Гэр (үнс)	Тн/өдөр	568.4	549.1	529.7	510.4	491.1	-	-	-	-	-
	Гэр дүн	Тн/өдөр	690.8	683.1	675.3	667.6	659.9	161.9	175.2	188.5	201.8	215.1
	Өрхийн дүн	Тн/өдөр	837.4	842.0	847.5	853	858.5	289.2	312.6	336.1	359.5	383.0
ААНБ-ын хог хаягдал	Тн/өдөр	194.1	211.7	229.4	247	264.7	240.7	260.0	279.2	298.4	317.6	
Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний хог	Тн/өдөр	12.3	12.7	13.2	13.6	14.1	20.8	21.6	22.3	23.1	23.8	
Бүгд			1043.8	1066.4	1049.1	1113.6	1137.3	550.7	594.2	637.6	681.0	724.4

Тайлбар: Төлөвлөлтийг “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийг чадавхийг бэхжүүлэх төсөл”-д хэрэглэгдсэн тооцооллын аргачлалыг хэрэглэн тооцов. Хуудас 1-19



Одоогийн хяналтын тогтолцоо дэлгэрэнгүй




7.2.2. Хөтөлбөр хэрэгжсэнээр бий болох хог хаягдлын менежментийн тогтолцоо




7.2.3 Хог хаягдлын урсгалын бүдүүвч




2014
Улаанбаатар хот
Зуны улирал




2014
Улаанбаатар хот
Өвлийн улирал



2016
Улаанбаатар хот
Зуны улирал



2016
Улаанбаатар хот
Өвлийн улирал



8.УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТҮҮНИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Хүснэгт 7 Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийн удирдлагын түвшин

№	Нийслэлийн түвшинд
1	Нийслэлийн Засаг даргын дэргэд энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах, хяналт тавих үүргийг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба хүлээнэ.
2	Захирагчийн Ажлын албаны дарга нь Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид тайлагнаж ажиллана.
3	Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах Ажлын хэсэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг төсвийн тооцооны хамт гарган Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
	Дүүргийн түвшинд
1	Дүүргийн Засаг даргын асуудал эрхэлсэн орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулж ажиллана.
2	Дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хэсэг нь дүүргийн түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, биелэлтийг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба /Ерөнхий менежер/-нд тайлагнах үүрэг хүлээнэ.
3	Дүүргийн Засаг даргын орлогчийн ажлын чиг үүрэгт ХХМ-ийн асуудлыг тусгаж өгнө.
4	Хог хаягдлын тээвэрлэгчийг дүүрэг дээр сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч, хяналт тавьж хариуцаж ажиллана. Ажлын гүйцэтгэлийг УБ ЗАА-нд тайлагнана.
	Хорооны түвшинд
1	Хорооны Засаг дарга нь дүүрэгтэй гэрээ байгуулсан хог тээвэрлэгч байгууллагатай хог цуглуулах тээвэрлэх ажлын графикийг хамтран боловсруулж батлан хэрэгжилтэнд өдөр тутам хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж ажиллана.
2	Хорооны Засаг дарга нь дэвсгэрийнхээ бүх байгууллага аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдлыг графикийн дагуу цуглуулж тээвэрлүүлэх, хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг зохион байгуулах, хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг хураах, төлбөрийн байдалд хяналт тавьж зөрчлийг арилгуулан ажиллана.
3	Нутаг дэвсгэртээ бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах, байгууллага, аж ахуйн нэгжийн гадна тохижилт, хог, цас, мөсний цэвэрлэгээ хийлгэж, хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллана.

9. ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ТЭДГЭЭРИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Хүснэгт 7 Гүйцэтгэх үүрэг, чиглэл

Оролцогч талууд	Гүйцэтгэх үүрэг
УДИРДАХ БАЙГУУЛЛАГА	
<p>Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба</p>	<ul style="list-style-type: none"> • Хогны хураамжийн хэмжээг судлан тогтоож батлуулах, мөрдүүлэх • Хог хаягдлыг эх үүсвэрээс устгах хүртэлх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн актуудыг боловсруулан, мөрдүүлэх • Хог хаягдлын норм, нормативын хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулах, батлуулах • Хог хаягдлын хэмжээ, түүний бүтцэд судалгаа хийж, бүртгэл хөтлөх • Хотын хэмжээнд хэрэгжих төсөл хөтөлбөрийг удирдан чиглүүлэх • Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр, устгах байгууламж, хогийн төвлөрсөн цэг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах, хяналт тавих • Хог тээврийн авто машины парк шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэх • Хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах • Зам талбайн үйлчлэгчдийн орон тоо, цэвэрлэгээний норм, норматив, үнэ тарифыг тогтоох
<p>Дүүргийн Засаг даргын тамгын газар (асуудал эрхэлсэн орлогч)</p>	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын талаар гарсан эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх • Хог хаягдлыг ачиж цуглуулах нэгдсэн хуваарийг баталж, мөрдүүлэх, хяналт тавих • Байгууллага, ААН-үүд, айл өрхийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх хог тээвэрлэгч байгууллагыг <u>сонгон шалгаруулж</u>, гэрээ байгуулж, хог хаягдлыг <u>ачиж, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, санхүүжүүлэх</u>: • Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, хальтиргаа гулгаа, ногоон байгууламжийн арчилгаа, үйлчилгээг зохион байгуулж, шаардагдах санхүүжилтыг өөрийн төсөвт жил бүр тусгаж, хяналт тавьж ажиллах • Хог хаягдлын талаар хороодод мэргэжил, арга зүйн зөвлөгөө, сургалт сурталчилгаа хийж ажиллах • Дүүргийн хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах • Хот тохижилтын ажилчдын хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудлыг сайжруулах • Иргэдээс гарсан гомдол, санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх • Тохижилт, хог хаягдлын талаар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн байгууллага, аж ахуйн <u>нэгжүүдэд хариуцлага хүлээлгэх</u> • Дүүрэг дээр зохион байгуулагдаж байгаа бүх нийтийн их цэвэрлэгээ, компанит ажилд шаардагдах багаж хэрэгсэл, машин техник, хүн хүчийг бэлтгэж хангах • Нийтийн эзэмшлийн зам талбайг хогийн саваар хангаж, тоо хэмжээг нэмэгдүүлэх, хогийн савыг эзэнжүүлж, арчлуулах • Эзэнгүй хур хог хаягдалд хяналт тавих эргүүл ажиллуулж, холбогдох байгууллагуудтай хамтарч, ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх арга хэмжээг авч ажиллах • Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан цэвэрлэгээ үйлчилгээний тусгай зориулалтын болон хог тээврийн автомашины ашиглалт, үйлчилгээнд хяналт тавьж ажиллах

	<ul style="list-style-type: none"> • Зам талбайн үйлчлэгчдийн багаж хэрэгслэлийг сайжруулах, боловсронгуй болгох, хангамжийг сайжруулах арга хэмжээ авах • Иргэд, олон нийт, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах санал санаачлагыг дэмжиж ажиллах
Гэр хороолол дахь Захирагчийн ажлын алба	<ul style="list-style-type: none"> • Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бодлого чиглэлийг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих • Нутаг дэвсгэрээ хоггүй байхад хяналт тавих, холбогдох шаардлага, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх • Иргэд, олон нийтэд хог хаягдалгүй байлгах мэдлэг ухамсрыг дээшлүүлэх ажлуудыг дүүрэг хороодтой зохион байгуулах • Тээвэрлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох, цуглуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих • Хог хаягдалдлын талаарх мэдээлэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд мэдэгдэж, удирдамж, чиглэл авсны дагуу, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
Хороо	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх хуваарь гаргаж <u>мөрдүүлэх, хяналт тавих</u> • Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх гэрээг цуцлах саналыг дүүргийн Засаг даргад хүргүүлэх • Хог хаягдлын чиглэлээрх хууль, эрх зүйн актуудыг мөрдөөгүй айл өрх, байгууллага, ААН-үүдэд хариуцлага хүлээлгэх • Айл өрх, байгууллага, ААН-үүдийн хог хаягдлаа ангилан ялгаж хаяж байгаа байдалд хяналт тавьж ажиллах • Орон сууцны хороолол, гэр хорооллын гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг хийлгэх • Нутаг дэвсгэрийн бүх байгууллага, аж ахуйн нэгжийн гадна тохижилт, хог, цас мөс цэвэрлэгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хариуцлага тооцох
ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА	
Мэргэжлийн хяналтын газар	<ul style="list-style-type: none"> • Хог цэвэрлэгээний биелэлтэд хяналт тавьж, дүгнэлт гаргаж, хариуцсан байгууллагуудад дүгнэлт хүргүүлэх, хянах • Хууль, журмыг зөрчсөн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид хуулийн хариуцлага тооцох
ТББ /Хөндлөнгийн хяналт/	<ul style="list-style-type: none"> • Нутаг дэвсгэрийн бүх байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн гадна тохижилт, хог, цас мөс цэвэрлэгээний байдалд хяналт тавьж, холбогдох байгууллагад уламжлаж, шийдвэрлүүлэх • Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах
ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА	
Хот тохижилтын газар	<ul style="list-style-type: none"> • Батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу төсөвлөгдсөн хөрөнгөнд багтаан хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийг хийх • Хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт дарж, устгах ажлыг байгальд халгүй технологиор хийж гүйцэтгэх • Золбин нохой, муурыг орчин үеийн технологийн дагуу устгаж, шатаах, арьс түүхий эдийг боловсруулах • Төвлөрсөн цэг дээр байгуулагдсан хог боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг хөтлөн явуулах
Ус сувгийн удирдах газар	<ul style="list-style-type: none"> • Цэвэрлэх байгууламжуудын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах • Бохир ус зайлуулах шугам сүлжээ, хоолойнуудын ашиглалтыг хэвийн байлгах
Орон сууц нийтийн аж	<ul style="list-style-type: none"> • Шинээр ашиглалтанд орсон болон хуучин бүртгэлтэй орон сууцнуудын бүртгэлийг тухайн нутаг дэвсгэрийн төр захиргааны

ахуйн удирдах газар	байгууллагад мэдэгдэх, чиг үүргийн дагуу ажиллах <ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг дүүргийн төсөвт төвлөрүүлэх
Хог тээвэрлэгч байгууллага	<ul style="list-style-type: none"> • Хороотой хамтран хог цуглуулж, тээвэрлэх хуваарь гарган хуваарийн дагуу ажиллах • Хогоо заавар журмын дагуу хадгалаагүй, уут саванд хийгээгүй, хуваарийн дагуу хогоо ачуулаагүй байгууллага, ААН-үүдийн талаар холбогдох төр захиргааны байгууллагад мэдэгдэх • Дүүрэгтэй байгуулсан гэрээний дагуу байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг хуваарийн дагуу ачиж тээвэрлэнэ. • Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг ачиж, тээвэрлэхдээ айл өрхүүдийн хашааны үүдэнд гаргаж, ачуулахад бэлэн болгож бэлтгэсэн хог хаягдлыг хог тээврийн автомашинд ачна.
Сууц өмчлөгчдийн холбоо	<ul style="list-style-type: none"> • Хороо, дүүрэгтэй хамтран хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг зохион байгуулах • Хороо, дүүрэгтэй хамтран иргэдэд чиглэсэн суралт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах, • СӨХ-ны эзэмшил талбайн хог, цас мөсийг цэвэрлэх • Хогийн сав, бункерын ашиглалт, засвар шинэчлэлийг хийх • Хог ачиж, цуглуулах хуваарь, хог хаягдлыг зүй зохистой хадгалах, ачуулах заавар журмын дагуу хог хаягдлыг хадгалж, ачуулах
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БА ХЭРЭГЛЭГЧ	
Байгууллага, аж ахуйн нэгж	<ul style="list-style-type: none"> • Байгууллага, аж ахуйн нэгжүүд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг харьяалах дүүргийн төсөвт төвлөрүүлж, дүүрэгтэй гэрээ байгуулсан хог тээвэрлэгч байгууллагаар үйлчлүүлнэ. • Хог хаягдлаа заавар журмын дагуу ангилан ялгаж, ил задгай хог хаялгүйгээр хог тээврийн автомашинд хогоо хуваарийн дагуу ачуулна. • Хог хаягдлын чиглэлээр гарсан хууль, тогтоомж, шийдвэрийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. • Хог хаягдлаа төвлөрүүлэн ачуулдаг байгууллага, ААН-үүд хог хаягдлыг хийсэхгүй, ил задгай тархахгүй байхаар зориулалтын битүү том хогийн савыг байршуулсан байна. • Хог хаягдлаа заавар журмын дагуу зориулалтын уутанд хийж, уутыг битүүмжилж, хог тээврийн автомашинд ачуулна. • Төр захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу хийгдэж байгаа бүх нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхтэй оролцоно. • Хог цэвэрлэгээний багаж, хэрэгслэлийг бэлтгэсэн байна. • Нийтийн эзэмшлийн зам талбай болон өөрийн байгууллагын орчинд ил задгай хог хаягдал хаясан иргэн, байгууллага, ААН-д хяналт, шаардлага тавьж, энэ талаар хороо болон холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэж ажиллана.
Иргэн ба айл өрх	<ul style="list-style-type: none"> • Гэр хорооллын айл өрх хог хаягдлаа заавар журмын дагуу савлаж, түр хадгалах ба хог тээврийн автомашин ирэхэд хогоо хашааны үүдэнд гаргаж ачуулахад бэлтгэж өгнө.. • Хог хаягдлаа заавар журмын дагуу ангилан ялгаж, зориулалтын уутанд хийж, хуваарийн дагуу хаяна. • Нийтийн эзэмшлийн зам, талбайд ил задгай хог хаяхгүй байх • Нийтийн эзэмшлийн зам талбайд ил задгай хог хаягдал хаясан иргэн, байгууллага, ААН-д шаардлага тавьж, энэ талаар хороо болон холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэж ажиллана.

10. ИРГЭДИЙН МЭДЛЭГ УХАМСРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Айл өрх, ААНБ-аас гарах хог хаягдалыг анхан шатны эх үүсвэр дээр ангилан ялгаж, гарах хог хаягдлын хэмжээг багасгах ажиллагааг дэмжих нэгдүгээр зорилтод хамаарна.

Нийслэлийн Засаг даргын 2011 оны 525 тоот захирамжаар 2011 оны хичээлийн жилээс эхлэн нийслэлийн нийт ЕБС-уудын 7-р ангид “Хог хаягдлын менежмент” сэдэвт хичээлийг оруулахаар шийдвэр гарсны дагуу Нийслэлийн Боловсролын газраас тусгай хөтөлбөр боловсруулан, хичээлийг 2 дахь жилдээ зааж байна.

Хог хаягдлын талаархи иргэд, олон нийтийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлуудыг авч хэрэгжүүлнэ.

- Хог хаяхгүй байх болон хог ангилан ялгах талаар нийтийг хамарсан сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх
- Хүүхдүүдэд хог хаяхгүй байх талаар цогц ойлголтыг олгох хичээлийг ЕБС болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт суулгаж өгөх
- Хог хаягдлын талаар батлагдсан хууль, журам, эрх зүйн баримт бичгийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар сурталчлах

11. ХОГ ХАЯГДЛЫГ ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ АНГИЛАН ЯЛГАХ ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

2013-2016 онд айл өрх болон байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг ангилан ялгах ажлыг эхлүүлэх бөгөөд хог хаягдлаа “Дахин ашиглах боломжтой” /хуванцар сав, шилэн сав, лааз, цэвэрхэн цаас/, “Бусад” /хүнсний хаягдал, тасалгааны ургамал, мод, резин, савхи, чулуу, шаазан гэх мэт/ гэсэн 2 хувилбараар ангилна.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулна. Хог ангилан ялгах тогтолцоо нэвтрүүлэх төлөвлөгөөг доорх хүснэгтэнд харуулав.

Хугацаа	Сүх-баатар	Чингэлтэй	Сонгино-хайрхан	Баянзүрх	Баянгол	Хан-Уул	Бага-нуур	Бага-хангай	Налайх	Нийт
2013 он	2	2	2	2	2	2	1	1	1	15
2014 он	3	3	2	3	3	3	2	1	3	24
2015 он	4	4	2	4	4	4	2		3	29
2016 он	4	4	4	4	4	4				24
Нийт										92

Гэр болон орон сууцны хороо бүрт 3-аас доошгүй агент /цэг/ байгуулж дахин ашиглах хаягдал болон хоёрдогч түүхий эдийг иргэдээс худалдан авна. Энэ ажлыг хоёрдогч түүхий эдээр хөдөлмөр эрхлэгчдийн үндэсний холбоотой хамтран зохион байгуулна. Хог хаягдал болон хоёрдогч түүхий эдийг худалдан авснаар иргэдийн орлогын нэг эх үүсвэр бүрдэнэ.

12.ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ

Хотын хэмжээнд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажиллагааг сайжруулахын тулд тогтолцооны өөрчлөлтийг хийнэ. Үүнд

- “Хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам”-ыг боловсруулах батлуулах
- Журмын дагуу дүүргүүд тээвэрлэгч байгууллагыг өөрсдөө сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, санхүүжүүлдэг тогтолцоонд шилжих
- Хог хаягдлыг тээвэрлэснээр биш хоггүй байгаа эсэхээр эцсийн үр дүнг үнэлж, дүгнэдэг, санхүүжүүлдэг байх
- Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйл ажиллагаанд мэдээллийн технологид суурилсан хяналтыг нэвтрүүлэх
- Хог цуглуулж, тээвэрлэх үйлчилгээнд цагийн хуваарь, тогтсон маршрутын системийг нэвтрүүлэх

13.ХОГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Ангилсан хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх ялгах, дахин боловсруулах ажлуудыг хийж эцсийн шатанд байгаль орчинд сөрөг нөлөөг бага үзүүлэх технологи ашиглан хогийн цэг дээр дарж устгах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.

- Цагаан давааны хогийн цэгт хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулах, шатаах үйлдвэр байгуулах /200-250 тн/
- Нарангийн энгэр болон Цагаан давааны хогийн цэгт барилгын хог хаягдлыг ангилан бутлаж, барилгын материал хийдэг үйлдвэр байгуулах
- Алслагдсан хороо, дүүргүүдэд (Налайх, Багануур, Багахангай, Партизан, Морингийн даваа) хог хаягдлыг хүлээн авч, ангилан ялгаж, дахин ашиглагдахгүй хог хаягдлыг устгадаг ландфилл технологи бүхий хогийн төвлөрсөн цэгүүдийг байгуулах
- Малын сэг зэм, малын гаралтай хог хаягдлын тээвэрлэлт, цуглуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, зориулалтын төвлөрсөн цэгийг Эмээлтэд байгуулах
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн, техник, технологийн шийдэл бүхий төслүүдийг сонгон шалгаруулж, дэмжиж ажиллана.
- Органик гаралтай хог хаягдлыг боловсруулж, био эрчим хүч, бордоо үйлдвэрлэх үйлдвэрийг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах

14.ГУДАМЖ, ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ АРЧИЛГААГ САЙЖРУУЛАХ

Гудамж, талбайн цэвэрлэгээ арчилгааг сайжруулах ажлыг эрчимжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч ажиллана.

- Гудамж талбайн цэвэрлэгээ, арчилгааг бүсчлэн тогтоох бөгөөд хотын төвийн хэсэг буюу Их тойрууг бүхэлд нь Хот тохижилтын газар хариуцна.
- Бусад бүсүүдийг тухайн дүүргийн дэргэдэх ОНӨҮГ арчилгаа, цэвэрлэгээг хариуцан ажиллана.
- Зам талбайн үйлчлэгчдийн тоог (2012 онд 352 үйлчлэгчтэй) ажлын ачаалал, хот байгуулалттай уялдуулан 2016 онд 800- д хүргэнэ.
- Цэвэрлэх талбайн цэвэрлэгээний үнэлгээг жилийн инфляци, ажлын ачаалалтай уялдаатайгаар нэмэгдүүлнэ.

15.ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО, ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллах бөгөөд ямар үр дүн гарч, дэвшүүлсэн зорилго, зорилтод хүрч чадсан эсэхээ тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд, хүрэх түвшинг дараах байдлаар томъёолов.

Хүснэгт 9: Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

№	Шалгуур үзүүлэлт	2012 он /гарааны түвшин/		2013		2014 он		2015		2016 он /барианы түвшин/	
		Өвөл	Зун	Өвөл	Зун	Өвөл	Зун	Өвөл	Зун	Өвөл	Зун
Хатуу хог хаягдлын үүсэх хэмжээ											
1	Хатуу хог хаягдлын үүсэх хэмжээ (тн/өдөр) Нийт • Орон сууц • Гэр хороолол	1085.2 345.6 726.3	576.8 406.9 169.9	1151.4 370.7 754.2	611.5 431.0 180.5	1217.5 395.8 782.0	646.3 455.1 188.5	1283.7 446 837.7	681 479.2 201.8	1349.9 477.4 864.5	715.7 503.3 212.4
2	Орон сууцны хорооллын хогны бүтэц (%) • Дахин ашиглагдах • Бусад	44.4 55.6	43.0 57.0	44.6 55.4	43.2 56.8	44.7 55.3	43.4 56.6	45.1 54.9	43.6 56.4	45.3 54.7	43.8 56.2
3	Гэр хорооллын хогны бүтэц (тн/өдөр) • Дахин ашиглагдах • Бусад	7.2 92.8	43.7 52.3	7.5 92.5	43.9 50.1	7.7 92.3	44.0 48.0	8.2 91.8	44.2 45.8	8.4 91.6	44.4 43.6
Хог цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ											
4	Үйлчилгээнд хамрагдах хүн амын хувийн жин (%) ▪ Орон сууц ▪ Гэр хороолол	-	100 63		100 70.0		100 80.0		100 90		100 95
5	Үүсэх нийт хогонд эзлэх хууль бусаар хаягдах хогны хувийн жин (%) ▪ Орон сууц ▪ Гэр хороолол	0 3.9	0 1.8	3.5	1.6	0 2.7	0 1.5	2.1	1.4	0 1.6	0 1.3
6	Ангилан тээвэрлэлтэд хамрагдах хүн амын хувийн жин (%) ▪ Орон сууц ▪ Гэр хороолол	3.3 0	6.6 0	6.6 0	9.8 0	9.8 0	13.1 0	16.4 0	16.4 0	19.7 0	19.7 0
7	Ангилан тээвэрлэх хогны хэмжээ (тонн/өдөр) ▪ Орон сууц	6.1 0	10.4 0	12.2 0	15.5 0	18.3 0	20.7 0	35.5 0	25.9 0	36.6 0	31.1 0

	▪ Гэр хороолол					
8	Хог ачих давтамж ▪ Орон сууц ▪ Гэр хороолол	<ul style="list-style-type: none"> • Дахин ашиглагдахгүй хогийг сард 2 удаа • Сард 1 удаа /Сард 2 удаа гэж тээвэрлэгчидтэй гэрээ байгуулсан / 		<ul style="list-style-type: none"> • Дахин ашиглагдахгүй хогийг долоо хоногт 1 удаа дахин ашиглах хогийг долоо хоногт 1 у даа • Сард 2 удаа 		<ul style="list-style-type: none"> • Дахин ашиглагдахгүй хогийг долоо хоногт 1 удаа дахин ашиглах хогийг долоо хоногт 1у даа • Сард 2 удаа
9	Хог цуглуулах тогтолцоо	<ul style="list-style-type: none"> • Орон сууцны хороолол түр цэгээс /орцноос/ гадаах цэгээс • Гэр хороолол, хашаа бүрээс 		<ul style="list-style-type: none"> • Орон сууцны хороолол түр цэгээс /орцноос/ гадаах цэгээс • Гэр хороолол, хашаа бүрээс, Контейнэрээс 		<ul style="list-style-type: none"> • Орон сууцны хороолол түр цэгээс /орцноос/ гадаах цэгээс • Гэр хороолол, хашаа бүрээс, Контейнэрээс
10	Тээврийн хэрэгслийн тоо	315	323	331	339	347
11	Ачигчийн тоо	500	516	532	548	564
12	Тээвэрлэх тогтолцоо	Шууд тээвэрлэх	Шууд тээвэрлэх	Шууд тээвэрлэх	Шууд тээвэрлэх	Шууд тээвэрлэх
13	Хэрэгжүүлэх байгууллага	<ul style="list-style-type: none"> • Хот /ХТГ/ • 6 ТҮК • ТҮТ-1 ДХХҮС-1 • Нийтлэг үйлчилгээний газар-4 • Хувийн хэвшил 	<ul style="list-style-type: none"> • Хот /ХТГ • 9 дүүрэг буюу нийтлэг үйлчилгээний газар-9/ОНӨҮГ/ • Хувийн хэвшил 	<ul style="list-style-type: none"> • Хот /ХТГ • 9 дүүрэг буюу нийтлэг үйлчилгээний газар-9/ОНӨҮГ/ • Хувийн хэвшил 	<ul style="list-style-type: none"> • Хот /ХТГ • 9 дүүрэг буюу нийтлэг үйлчилгээний газар-9/ОНӨҮГ/ • Хувийн хэвшил 	<ul style="list-style-type: none"> • Хот /ХТГ • 9 дүүрэг буюу нийтлэг үйлчилгээний газар-9/ОНӨҮГ/ • Хувийн хэвшил
14	Нэгж зардал /төг/тн/	14000-27500		20700-39500		29700-55500
Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээ						
16	Цэвэрлэгээний арга	Голдуу гар ажиллагаа ба техник ашиглах		Голдуу гар ажиллагаа ба техник ашиглах		Голдуу гар ажиллагаа ба техник ашиглах
17	Цэвэрлэх талбай (м2)	4 923 502	5 400 000	5 900 000	6 400 000	6 900 000
18	Хэрэгжүүлэх байгууллага	Дүүргийн төсвөөс		Дүүргийн төсвөөс		Дүүргийн төсвөөс

		санхүүжүүлж хувийн хэвшлийн гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлнэ			санхүүжүүлж хувийн хэвшлийн гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлнэ			санхүүжүүлж хувийн хэвшлийн гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлнэ		
19	Зам талбайн үйлчлэгчдийн тоо	352		676	700		750	800		
20	Нэгж зардал (төг/тн)	50		150	150		200	250		
4.Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах үйл ажиллагаа (рисайкл), дундын боловсруулалт										
21	Ялгах цех			ХТГ						
22	Байршил	НЭРЦ		НЭРЦ	НЭРЦ		НЭРЦ	НЭРЦ		
23	Ирэх хэмжээ (тн/жил)									
24	Ялгаж авах түүхий эдийн хэмжээ (тн/жил)	-		-	1500		-	2493		
25	RDF-ийн үйлдвэр									
	• Байршил	НЭРЦ		НЭРЦ	НЭРЦ		НЭРЦ	НЭРЦ		
	• Үйлдвэрлэх хэмжээ (тн/жил)	-		-	300		-	474		
	• Нэгж зардал (төг/тн)	Байхгүй			45000			56611		
	• Эх үүсвэр дээр рисайклд орох хэмжээ (тн/өдөр)	42	46.0		227.6.0	232.2		432.4	436.0	
	• Рисайклд орох нийт хогны бүх хогонд эзлэх хувийн жин	4.2%	8.4%		23.0%	60.1%		44.7%	60.1%	
	• Рисайкл үйл ажиллагааны тогтолцоо	Төрийн дэмжлэггүйгээр хувийн хэвшил голлон гүйцэтгэх			Төрийн дэмжлэггүйгээр хувийн хэвшил голлон гүйцэтгэх			Төрийн дэмжлэггүйгээр хувийн хэвшил голлон гүйцэтгэх		
5.Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа										
32	Үйл ажиллагааны аргачлал	НЭХЦ эрүүл ахуйн шаардлага хангах ландфил /SL/-ийн түвшинд 4 Бусад 3, ТХЦ SL – ийн түвшин 2		НЭХЦ эрүүл ахуйн шаардлага хангах ландфил /SL/-ийн түвшинд 4 Бусад 3, ТХЦ SL – ийн түвшин 2	НЭХЦ эрүүл ахуйн шаардлага хангах ландфил /SL/-ийн түвшинд 4 Бусад 3, ТХЦ SL –ийн түвшин 2	НЭХЦ эрүүл ахуйн шаардлага хангах ландфил /SL/-ийн түвшинд 4 Бусад 3, ТХЦ SL – ийн түвшин 2	НЭХЦ эрүүл ахуйн шаардлага хангах ландфил /SL/-ийн түвшинд 4 Бусад 3, ТХЦ SL –ийн түвшин 2	НЭХЦ эрүүл ахуйн шаардлага хангах ландфил /SL/-ийн түвшинд 4 Бусад 3, ТХЦ SL –ийн түвшин 2	НЭХЦ эрүүл ахуйн шаардлага хангах ландфил /SL/-ийн түвшинд 4 Бусад 3, ТХЦ SL –ийн түвшин 2	
33	Байршил	НЭХЦ МДХЦ		НЭХЦ МДХЦ	НЭХЦ МДХЦ		НЭХЦ МДХЦ	НЭХЦ МДХЦ		

		НХЦ ЦДХЦ	НХЦ ЦДХЦ	НХЦ ЦДХЦ	НХЦ ЦДХЦ	НХЦ ЦДХЦ
34	Хотын төвөөс алслагдах зай /км/	НЭХЦ 4 МДХЦ 23 НХЦ 38 ЦДХЦ 9	НЭХЦ 4 МДХЦ 23 НХЦ 38 ЦДХЦ 9	НЭХЦ 4 МДХЦ 23 НХЦ 38 ЦДХЦ 9	НЭХЦ 4 МДХЦ 23 НХЦ 38 ЦДХЦ 9	НЭХЦ 4 МДХЦ 23 НХЦ 38 ЦДХЦ 9
35	Хариуцагч байгууллага	НЭХЦ ХТГ МДХЦ ХТГ НХЦ Над ЦДХЦ ХТГ	НЭХЦ ХТГ МДХЦ ХТГ НХЦ Над ЦДХЦ ХТГ	НЭХЦ ХТГ МДХЦ ХТГ НХЦ Над ЦДХЦ ХТГ	НЭХЦ ХТГ МДХЦ ХТГ НХЦ Над ЦДХЦ ХТГ	НЭХЦ ХТГ МДХЦ ХТГ НХЦ Над ЦДХЦ ХТГ
37	Ажилчдын тоо	НЭХЦ 31 МДХЦ 6 НХЦ 1 ЦДХЦ 10	НЭХЦ 31 МДХЦ 6 НХЦ 1 ЦДХЦ 10	НЭХЦ 35 МДХЦ 10 НХЦ 3 ЦДХЦ 10	НЭХЦ 35 МДХЦ 10 НХЦ 3 ЦДХЦ 10	НЭХЦ 40 МДХЦ 10 НХЦ 3 ЦДХЦ 10
38	Дарж булах нэгж зардал (төг/тн)	НЭХЦ 2080 МДХЦ 2080 НХЦ 970 ЦДХЦ 2080		НЭХЦ 4160 МДХЦ 4160 НХЦ 1940 ЦДХЦ 4160		НЭХЦ 5200 МДХЦ 5200 НХЦ 2425 ЦДХЦ 5200
40	Ландфилын төхөөрөмж үндсэн	НЭХЦ: Бульдозер 3, Эксоватор 1, Усны машин 1, Самосвал 2, МДХЦ: Бульдозер 1 НХЦ: Байхгүй		НЭХЦ: Бульдозер 3, Эксоватор 1, Усны машин 1, Самосвал 2, МДХЦ: Бульдозер 1, Самосвал 1 НХЦ: Бульдозер 1, Самосвал 1 ЦДХЦ: Бульдозер 1, Дугуйт ковш 1, Эксоватор 1, Усны машин 1, Самосвал 2		НЭХЦ: Бульдозер 3, Эксоватор 1, Усны машин 1, Самосвал 2, МДХЦ: Бульдозер 1, Самосвал 1 НХЦ: Бульдозер 1, Самосвал 1 ЦДХЦ: Бульдозер 1, Дугуйт ковш 1, Эксоватор 1, Усны машин 1, Самосвал 2
6. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ						
41	Урьдчилан сэргийлэх үйлчилгээ болон жижиг	ХТГ-ийн харьяа	ХТГ-ийн харьяа	ХТГ-ийн харьяа	ХТГ-ийн харьяа	ХТГ-ийн харьяа

	хэмжээний засварын ажил	засварын цех	засварын цех	засварын цех	засварын цех	засварын цех
42	Томоохон засварын ажил	Хувийн засварын цех	Хувийн засварын цех	Хувийн засварын цех	Хувийн засварын цех	Хувийн засварын цех
43	Хэрэгжүүлэх байгууллага	ХТГ	ХТГ	ХТГ	ХТГ	ХТГ
44	Засвар үйлчилгээний ажилчид	Дарга 1 Менежер 1 Инженер 1 Механик, бусад 7 Нярав, бусад 13		Дарга 1 Менежер 1 Инженер 1 Механик, бусад 10 Нярав, бусад 20		Дарга 1 Менежер 1 Инженер 1 Механик, бусад 10 Нярав, бусад 20
1. Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээнээс бусад ХХМ-ийн үйл ажиллагааны санхүүгийн асуудлууд						
45	Нэгж зардал /төг/тн/	15810		16500		17590
46	Орлогын эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> • Хог гарсны төлбөр • Дүүргийн төсөв • Хотын төсөв Булах төлбөр • RDF 		<ul style="list-style-type: none"> • Хог гарсны төлбөр • Дүүргийн төсөв • Хотын төсөв Булах төлбөр • RDF 		<ul style="list-style-type: none"> • Хог гарсны төлбөр • Дүүргийн төсөв • Хотын төсөв Булах төлбөр • RDF
47	Нийт орлого /сая. Төг/	4403		5600		6300
48	Төлбөр цуглуулах хувь хэмжээ <ul style="list-style-type: none"> • Өрх /орон сууц/ • Өрх / гэр хороолол/ • ААН, байгууллага 	90% 63% NA		93% 70% 100%		95% 80% 100%
49	Хатуу хог хаягдлын менежментийн нийт орлогод эзлэх хогны хураамжийн орлогын хувь	90%		91%		91%
50	Хатуу хог хаягдлын менежментийн нийт орлогод эзлэх дундын боловсруулалтын зардал	0%		0.3%		0.5%
51	Хатуу хог хаягдлын менежментийн нийт орлогод эзлэх хогийн төвлөрсөн цэгийн зардал	9.4%		13.5%		16.4%
52	Нэг иргэнд ногдох нийт	4003		4200		4475

	зардал / төг/жил/					
8.Эмнэлгийн болон аюултай хог хаягдал						
55	Үүсэх хэмжээ (тн/өдөр)	Ерөнхий хог 16.9 Халдвартай, аюултай хог 1.8		Ерөнхий хог 17.3 Халдвартай, аюултай хог 1.9		Ерөнхий хог 18.9 Халдвартай, аюултай хог 2.0
56	Эх үүсвэр дээр нь боловсруулах	Ерөнхий хог: Хувийн компани цуглуулах Халдвартай аюултай хог: Эх үүсвэр дээр нь бүрэн боловсруулах эсвэл гадны байгууллагаар гүйцэтгүүлэх		Ерөнхий хог: Хувийн компани цуглуулах Халдвартай аюултай хог: Эх үүсвэр дээр нь бүрэн боловсруулах эсвэл гадны байгууллагаар гүйцэтгүүлэх		Ерөнхий хог: Хувийн компани цуглуулах Халдвартай аюултай хог: Эх үүсвэр дээр нь бүрэн боловсруулах эсвэл гадны байгууллагаар гүйцэтгүүлэх
57	Дарж булах	Ерөнхий хог: Эрүүл ахуйн шаардлага хангах ландфил хийх Халдвартай аюултай хог: Эх үүсвэр дээрээ боловсруулалтад ороогүй хаягдлыг хогийн цэг рүү нэвтрүүлэхийг хориглох		Ерөнхий хог: Эрүүл ахуйн шаардлага хангах ландфил хийх Халдвартай аюултай хог: Эх үүсвэр дээрээ боловсруулалтад ороогүй хаягдлыг хогийн цэг рүү нэвтрүүлэхийг хориглох		Ерөнхий хог: Эрүүл ахуйн шаардлага хангах ландфил хийх Халдвартай аюултай хог: Эх үүсвэр дээрээ боловсруулалтад ороогүй хаягдлыг хогийн цэг рүү нэвтрүүлэхийг хориглох
58	Дарж булах үйл ажиллагааг гүйцэтгэх байгууллага	ХТГ		ХТГ		ХТГ
9.Үйлдвэрийн хог хаягдал						
59	Үүсэх хэмжээ (тн/өдөр)	Аюулгүй хог 83.9 Аюултай хог 0.1		Аюулгүй хог 93.9 Аюултай хог 0.1		Аюулгүй хог 109.6 Аюултай хог 0.1
60	Боловсруулах, устгах (дарж булах)	Аюулгүй хог: Хотын хатуу хог хаягдлыг төвлөрсөн цэг дээр даруулах Аюултай хог: аюултай хог		Аюулгүй хог: Хотын хатуу хог хаягдлыг төвлөрсөн цэг дээр даруулах Аюултай хог: аюултай хог		Аюулгүй хог: Хотын хатуу хог хаягдлыг төвлөрсөн цэг дээр даруулах Аюултай хог: аюултай хог хаягдлыг

		хаягдлыг боловсруулах, устгах байгууламж байгуулагдах хүртэл эх үүсвэр дээр нь хадгалах		хаягдлыг боловсруулах, устгах байгууламж дээр боловсруулах, устгах, дарж булах		боловсруулах, устгах байгууламж дээр боловсруулах, устгах, дарж булах			
61	Хэрэгжүүлэх байгууллага	Аюулгүй хог: ХТГ Аюултай хог: аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах байгууламж байгуулагдах хүртэл уг хаягдлыг үүсгэгч этгээд		Аюулгүй хог: ХТГ Аюултай хог: аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах байгууламжийн үйл ажиллагааг хариуцах байгууллага (хувийн компани)		Аюулгүй хог: ХТГ Аюултай хог: аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах байгууламжийн үйл ажиллагааг хариуцах байгууллага (хувийн компани)			
10.Барилгын хог хаягдал									
63	Үүсэх хэмжээ (тн/өдөр)	75.0	152.2		84.0	176.5		98.0	198.9
64	Дарж булах	Барилга угсралтын ажлын зөвшөөрөл авах үед барилгын хогийг ТХЦ рүү тээвэрлэх төлөвлөгөө гаргаж байх үүргийг хүлээлгэж, улмаар ТХЦ-үүдэд ирэх хэмжээг хянах байдлаар хяналтын тогтолцоог бүрдүүлнэ		Барилга угсралтын ажлын зөвшөөрөл авах үед барилгын хогийг ТХЦ рүү тээвэрлэх төлөвлөгөө гаргаж байх үүргийг хүлээлгэж, улмаар ТХЦ-үүдэд ирэх хэмжээг хянах байдлаар хяналтын тогтолцоог бүрдүүлнэ		Барилга угсралтын ажлын зөвшөөрөл авах үед барилгын хогийг ТХЦ рүү тээвэрлэх төлөвлөгөө гаргаж байх үүргийг хүлээлгэж, улмаар ТХЦ-үүдэд ирэх хэмжээг хянах байдлаар хяналтын тогтолцоог бүрдүүлнэ			

19. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийн шатанд урьдчилан тооцоолоогүй эрсдлүүд учирч болзошгүй тул ямар эрсдэл, бэрхшээлүүд гарч болох, түүнийг хэрхэн даван туулах талаар дараах томъёоллыг гаргаж байна.

№	Учирч болох эрсдлүүд	Шийдвэрлэх арга зам	Хариуцах байгууллага
	<ul style="list-style-type: none"> Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд учирч болох эрсдлүүд, шийдэл 		
.1.	Машин, техникийн тоо хүчин чадал хүрэлцэхгүй байх	<ul style="list-style-type: none"> Цаг үеийн зохицуулалтыг ЗАА, дүүргүүдийн ЗДТГ хариуцан хийнэ. Жил бүр парк шинэчлэл хийж 1 хороонд 3-с доошгүй хог тээврийн машинуудыг ажиллуулна. Үүнд Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр жил бүр дутагдалтай машин, техникийн судалгааг гарган хэрэгцээт машиныг авах ажлыг зохион байгуулна. 	<ul style="list-style-type: none"> ЗАА ТХХУХэлтэс
.2.	Эх үүсвэр дээр ангилалдсан дахин ашиглах хаягдлыг цуглуулах машин техник, хүн хүч хүрэлцэхгүй байх	<ul style="list-style-type: none"> Ангилан ялгалт явуулж эхэлхээр дахин ашиглагдах хаягдлыг цуглуулах тээвэрлэх ажлыг 2 догч түүхий эдээр хөдөлмөр эрхлэгчидийн холбоо, хувийн хэвшлийнхэнтэй хамтран ангилсан дахин ашиглагдах хаягдлыг тээвэрлэх машины асуудлыг дүүргийн ЗДТГ зохион байгуулна. 	<ul style="list-style-type: none"> ЗАА ТХХУХэлтэс, ХТГ, тээвэрлэгч ААНБ-д ХТЭХЭХ, БААН
.3.	ТҮК-үүдыг татан буугдахаар асуудал яригдаж эхэлсэн. Үүнээс үүсэх эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх эрхийн төсөл шалгаруулах, санхүүжүүлэх, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэх журамыг яаралтай батлуулах Дүүргээс зарлах сонгон шалгаруулалтын дагуу хог тээвэрлэгч байгууллагуудыг оруулах замаар асуудлыг шийдвэрлэнэ. 	<ul style="list-style-type: none"> Шуурхайн улирдлагаар ЗАА хангаж ажиллах Журам батлуулах
2. Санхүү, хөрөнгө мөнгөний дутагдал түүнээс үүсэх эрсдэл, шийдвэрлэх арга зам			
2.1.	Хог ангилан ялгалт нэвтрүүлэхэд тээвэрлэлт, ангилалтын зардлаас үүсэх эрсдэл	<ul style="list-style-type: none"> Нийслэл, дүүргийн төсвөөс тусгайлан хөрөнгө гаргана. Мөн хоёрдогч түүхий эдээр хөдөлмөр эрхлэгчдийн холбооноос хөрөнгө гаргана. 	<ul style="list-style-type: none"> Шуурхайн удирдлагаар ЗАА хангаж ажиллах
2.2	Хогны төлбөрийн үнэ тариф, хураалтаас хамаарч учирч болох эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Хогны төлбөрийг бүрэн хураах арга хэмжээг зохион байгуулна Хогны төлбөрийн үнэ, тарифыг шинэчлэнэ Нийслэл, дүүргийн төсвөөс нэмэлт санхүүжилтийг жил бүр олгоно 	<ul style="list-style-type: none"> ДЗДТГ ЗАА үнэ тарифийн асуудлыг тодотгож шийдлийн хувилбар

		боловсруулж удирдлагад танилцуулж, шийдүүлэх
2. Ангилан ялгалт болон дахин боловсруулах үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, шийдвэрлэх арга зам		
3.1. Хог ангилан ялгаж хаях ажил хэзээнээс эхлэх, хэдэн төрлөөр ангилуулах, Нийслэлийн хүн амын ухамсар бэлэн эсэх.	<ul style="list-style-type: none"> 3 сарын 1-ээс Хоёрдогч түүхий эдийг худалдан авах журам, Хог ангилан ялгах, зүй зохистой хадгалах, хаях журмыг боловсруулан гаргах, сургалт сурталчилгаа, танилцуулганы ажил хийгдэх бөгөөд 5-р сарын 1-ээс Гэр хороонд үнс, дахин ашиглах боломжтой, боломжгүй гэсэн 3 ангиллаар, БААН ,Орон сууцны оршин суугчдыг дахин ашиглах боломжтой, боломжгүй гэж 2 ангилуулан гэр хорооны 2, орон сууцны 13, нийт 15 хороонд эхлүүлнэ. 2016 онд нийт 92 хороонд ангилан ялгалтын ажил хийгднэ. 	<ul style="list-style-type: none"> ЗАА ТХХУХэлтэс
2.3 Ангилсан хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой гарах эрсдэл	<ul style="list-style-type: none"> Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт Хог хаягдал ангилах, боловсруулах, шатаах үйлдвэрийг 2013 онд байгуулна. Хоногт 200-250 тн хог боловсруулна. Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт Хог хаягдал ангилах, боловсруулах, шатаах хатуу түлш үйлдвэрлэх үйлдвэрийг байгуулсан. Хоногт 50 тн хог хаягдал боловсруулж 2 тн хатуу түлш үйлдвэрлэнэ. 15 хорооноос 160 тонн хог хаягдал гарна гэж үзвэл 80 тонн нь ангилагдсан дахин ашиглах боломжтой хог хаягдлыг Койкагийн үйлдвэрт нарийвчилсан ангилалт хийж, ангилагдсан түүхий эдийг 2-догч түүхий эдийн цэг, агентад өгч болох бөгөөд үлдэгдийг Цагаан давааны хогийн цэгт шатаах боломжтой юм. Мөн хог хаягдлыг ашиглан дизель нэрэх хувийн хэвшлийн санаачлагуудыг судлан бодлогоор дэмжиж ажиллана. 	<ul style="list-style-type: none"> ЗАА ТХХУХэлтэс, ХТГ
3. Аюултай хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтээс гарах эрсдэл, шийдвэрлэх арга зам.		
4.1. Аюултай хог ачиж тээвэрлэх зориулалтын машин, техник дутагдах	<ul style="list-style-type: none"> Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр аюултай хог үүсгэгч тухайн БААН-н хөрөнгөөр машин, техникүүдийг авах арга хэмжээ авна. Энэ асуудлыг дагнан хариуцаж ажиллах мэргэжилтнийг ЗАА-нд 2013 оноос бий болгон ажиллуулж байна 	<ul style="list-style-type: none"> ДЗДТГ УБ ЗАА

-----oOo-----